



**ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 07 өдөр

Дугаар A/02

Бэрх хот

Дотоод хяналт шалгалтын
ажлын хэсгийг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хууль, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр “Нийтлэг журам батлах тухай” (ААНБ-ын дотоод хяналт шалгалт)-ын тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Мичидмаа (Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Болорцэцэг (Татварын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: П.Янжмаа (Санхүү албаны дарга)

2. Дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө, журам, боловсруулж баталгаажуулж үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн орлогч (Н.Бахыт)-д даалгасугай

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Захирагчийн ажлын албаны даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  О.МЯГМАРСҮРЭН

232603004